



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 202

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын үндэсний музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 24,782,103.75 (хорин дөрвөн сая долоон зуун наян хоёр мянга нэг зуун гурван төгрөг далан таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 19,825,682.88 (арван есөн сая найман зуун хорин таван мянга зургаан зуун наян хоёр төгрөг наян найман мөнгө) хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Орхон А33А” төрийн өмчит хувьцаат компанийд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Монголын үндэсний музейн захирал Д.Сүхбаатар, “Орхон А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цогтгэрэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮРП
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн
20 дугаар тоотдоолын хавсралт



000169 - 1116262883

Бүртгэлтэй,

"Орхон Азза" ТӨХК-д балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулаалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын чнэ	Хурумтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	Ниссан максима, УБЗ 00-27, суудлын, арал: 1N4BA41E87C827931	2007/2014	52589	24,782,103.75	19,825,682.88	4,956,420.87
				24,782,103.75	19,825,682.88	4,956,420.87
				(хорин дөрвөн сая долоон зуун наян хоёр мянга нэг зуун түрван төгрөг далан таван мөнгө)	(арван есөн сая найман зуун хорин таван мянга зургаан зуун наян хоёр төгрөг наян найман мөнгө)	(дөрвөн сая есөн зуун тавин зургаан мянга дөрвөн зуун хорин төгрөг наян долоон мөнгө)

Нийт дүн